



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2013 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 36.

Улаанбаатар хот

Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах,
ажилд томилох тухай

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Бүтээн байгуулалтын томоохон төсөл хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 71 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газраас Тавантолгойн нүүрсний орд газарт 300 МВт-ын цахилгаан станц барих, уг төслийн санхүүжилтүг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан “Тавантолгойн Цахилгаан Станц” барих төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулсугай.

Хоёр.“Тавантолгойн цахилгаан станц” барих төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирлаар Мэндсайханы Энхсайханыг 2013 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

Гурав. М.Энхсайханы албан тушаалын цалинг Сангийн сайдын 86 дугаар тушаалын хавсралт “Засгийн газрын гадаад зээл тусlamжийн хөрөнгөөр санхүүжих төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг үндэслэн тооцож олгохыг Санхүү хөрөнгө оруулалтын газар /С.Баяrbat/-т даалгасугай.


Дөрөв. Төслийг хэрэгжүүлэх талаар дараах арга хэмжээнүүдийг авч ажиллахыг төслийн удирдах хорооны дарга Д.Дэлгэрцогт, төслийн нэгжийн захирал М.Энхсайхан нарт даалгасугай.

4.1. Бүтээн байгуулалтын төсөл, объектийн ажлын зураг төсөл, техник-эдийн засгийн үндэслэлийг захиалж боловсруулах, төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргуулах;

4.2. Төслийн санхүүгийн болон эдийн засгийн тооцоог хийлгэж, төр, хувийн хэвшил болон гадаадын хөрөнгө оруулагчдын саналуудыг авч хөрөнгө оруулалтын оновчтой хувилбар боловсруулах;

4.3. Төслийн нэгжийн зохион байгуулалтын бүтцийг батлан, ажиллах зардлын хязгаарыг тогтоож, Хөгжлийн банкнаас шаардлагатай санхүүжилтийг гаргах ажлыг зохион байгуулах;

Тав. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Л.Батсайхан/-т даалгасугай.



0800116